

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

Аудитын код: ӨМА-2025/47-ШТА-ГА

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Аудитор Т.Хишигбат

Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn

Аудитор М.Номиндарь

Утас: 70533552 Цахим хаяг: Nomindarim@audit.gov.mn

Даланзадгад хот 2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/20

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. "Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байдал, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар болон Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг аудитор (Т.Хишигбат)-т үүрэг болгосугай.

3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитор (Т.Хишигбат) даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

4625010060



ГАРЧИГ

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	3
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	4
Аудитын зорилго	4
Аудитын хамарсан хүрээ	4
Аудитын арга зүй	4
Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:	4
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:	5
БҮЛЭГ-1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИД ХИЙСЭН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	6
А.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн хяналт хийгдсэн нь баримтаар нотлогдохгүй байна.	6
А.2. Барилгын ажлын захиалагчийн дүрмийг мөрдөж ажиллах шаардлагатай байна.	7
А.3. Барилга байгууламжийн захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээг захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй байгуулаагүй байна.	8
БҮЛЭГ-2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	9
Б.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн авто зам, замын байгууламжид захиалагч чиг үүргээ хэрэгжүүлсэн байна.	9
Б.2. Авто зам, замын байгууламжийн өндөр дүнтэй ажилд зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан байна.	10
Б.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн авто зам, замын байгууламжийн захиалагчийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.	10
БҮЛЭГ-3 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН БАЙНА	11
ДҮГНЭЛТ	14
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	15



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХТО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт-1. Аймаг, сумдын ИТХ-аар 2024 онд ОНТХО-н ажлын тоо, төсөв, санхүүжих дүн
- Хүснэгт-2. ОНТХО-аар 2024 онд хийгдэх барилга, байгууламж, авто зам, замын байгууламж, дэд бүтцийн ажлууд
- Хүснэгт-3. Аймаг, сумын ОНТХО-аар 2024 онд хийгдсэн авто зам, замын байгууламжийн ажил
- Хүснэгт-4. Захиалагчийн хяналтын гэрээ байгуулан, санхүүжилт олгосон байдал
- Хүснэгт-5. Захиалагчийн хяналтыг зардлыг зарцуулсан байдал



Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байдал, үр дүнд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг Аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдсан барилга байгууламжид хийсэн захиалагчийн хяналт үр дүнтэй байна уу?
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн авто зам, замын байгууламжид хийсэн захиалагчийн хяналт үр дүнтэй байна уу?
- Захиалагчийн хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна уу?

Аудитын хамарсан хүрээ

Аудитад орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтад захиалагчийн хяналт хийсэн аймаг, сумын ЗДТГ, ГХБХБГ болон захиалагчийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр төлөөлөн гүйцэтгэсэн хуулийн этгээдийн гэрээний хэрэгжилт, үр дүнтэй хийж гүйцэтгэсэн байдлыг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын аудитын стандарт MNS 6817-5:2020, гүйцэтгэлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, захиалагчийн хяналтын зардлын төлөвлөгөө, зарцуулалтыг баримт, материал, гэрээ болон бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэсэн.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Барилгын тухай хууль,
- Газрын тухай хууль,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- Авто замын тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 343 дугаар тогтоол,
- Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоол,
- Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны "Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрөл батлах" тухай 83 дугаар тушаал,
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх” журам
- Барилгын ажлын захиалагчийн дүрэм,
- Барилгын төсөв зохиох дүрэм



- Барилга байгууламжийн үнэ бүрдэл, төсөв зохиох норм, дүрэм, стандарт,
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актууд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул хэрэгжүүлж, аудитор Т.Хишигбат, М.Номиндарь нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн.



БҮЛЭГ-1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИД ХИЙСЭН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн хяналт хийсэн нь баримтаар нотлогдохгүй байна.

1.1 Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ” хэмээн заасан бөгөөд энэ нь барилга байгууламжийн захиалагчийн чиг үүргийг хуульчилсан байна.

1.2 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн “2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 19/28 дугаар тогтоолын тавдугаар хавсралтаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, их засварын нэр төрөл, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нийт 174 ажил батлагдсан байна.

1.3 Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2024 оны орон нутгийн төсвийн тодотголд тусган, нийт 361 нэр төрөл бүхий хөрөнгө оруулалт, их засварын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажлыг тус тус баталсан байна.

Хүснэгт-1. Аймаг, сумдын ИТХ-аар 2024 онд ОНТХО-н ажлын тоо, төсөв, санхүүжих дүн

/мянган төгрөг/

№	Сумын нэрс	ОНТХО-аар хийгдэх нийт хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний тоо	ОНТХО-аар хийгдэх нийт төсөл арга хэмжээний тоо төсөв	ОНТХО-аар хийгдэх нийт төсөл арга хэмжээний 2024 онд санхүүжих дүн
1	Баяндалай	3	40,000.0	40,000.0
2	Баян-Овоо	16	876,419.0	749,865.1
3	Булган	7	150,000.0	150,000.0
4	Гурвантэс	30	3,917,259.0	3,718,330.0
5	Даланзадгад	52	13,983,722.2	13,983,722.2
6	Манлай	6	228,600.0	228,600.0
7	Мандал-Овоо	0	-	-
8	Ноён	16	377,800.0	377,800.0
9	Номгон	3	25,000.0	25,000.0
10	Сэврэй	16	709,456.3	709,456.3
11	Ханбогд	104	120,064,154.0	108,657,226.4
12	Ханхонгор	5	118,000.0	118,000.0
13	Хүрмэн	0	-	-
14	Цогт-Овоо	12	190,000.0	190,000.0
15	Цогтцэций	91	13,064,695.4	13,064,695.4
16	Аймаг	174	1,110,923,144.4	435,683,911.5
Нийт дүн		535	1,264,668,250.3	577,696,606.9

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-н 2024 оны төсвийн тодотгол баталсан тогтоолууд

1.4 Мандал-Овоо, Хүрмэн сумдын хувьд 2024 онд ОНТХО-аас санхүүжих төсөл, арга хэмжээг батлаагүй байна.

1.5 Сумдын нийт ОНТХО-н төсөвт Ханбогд сумын 78.1%, Даланзадгад сум 9.1%, Цогтцэций сумын 8.5%, Гурвантэс сум 2.5%, бусад 11 сум нийлээд 1.8%-г эзэлж байна.



1.7 Энэ нь хүн ам цөөн, өөрийгөө санхүүжүүлэх боломжгүй жижиг сумдад хөрөнгө оруулалтын тэгш хуваарилалт хийх бодлого баримтлах шаардлагатай болохыг харуулж байна.

1.8 Аймгийн ОНТХО-аар хэрэгжүүлэх 174 төсөл, арга хэмжээнээс 113, сумдын хэмжээнд батлагдсан 361 төсөл, арга хэмжээнээс 111 нь барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, их засвар хийх, дулаан, цэвэр/бохир ус, цахилгаан хангамжийн шугам сүлжээ, авто зам, замын байгууламжийн ажлууд байна.

Хүснэгт-2. ОНТХО-аар 2024 онд хийгдэх барилга, байгууламж, авто зам, замын байгууламж, дэд бүтцийн ажлууд /мянган төгрөг/

№	Сум нэрс	ОНТХО-аар хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний тоо	ОНТХО-аар хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төсөв	ОНТХО-аар хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 2024 онд санхүүжих дүн
1	Баяндалай сум	1	10,000.0	10,000.0
2	Баян-Овоо сум	4	254,000.0	254,000.0
3	Булган сум	1	20,000.0	20,000.0
4	Гурвантэс сум	7	1,175,181.2	1,172,249.7
5	Даланзадгад сум	21	11,483,232.9	11,483,232.9
8	Ноён сум	1	20,000.0	20,000.0
10	Сэврэй сум	4	475,397.3	475,397.3
11	Ханбогд сум	49	114,952,611.8	103,545,684.3
12	Ханхонгор сум	1	8,000.0	8,000.0
14	Цогт-Овоо сум	1	20,000.0	20,000.0
15	Цогтцэций сум	21	6,240,626.9	6,013,927.4
Сумын нийт дүн		111	134,659,050.1	123,022,491.6
16	Аймаг	113	1,044,864,618.9	381,562,250.0
Нийт дүн		224	1,179,523,669.0	504,584,741.6

Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-н 2024 оны төсвийн тодотгоол баталсан тогтоолууд

1.9 Эдгээр барилга, байгууламжийн ажлуудад захиалагчийн хяналт гүйцэтгэх явцад барилгын ажлын үе шат бүрд хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдэлгээний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтийг тодорхойлуулсан баримт байхгүй байна.

1.10 Энэ нь барилгын бат бөх байдал, ашиглалтын аюулгүй байдал, иргэдийн амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх бодит эрсдэл үүсгэх нөхцөл бүрдүүлж байна. Иймд тус зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

2. Барилгын ажлын захиалагчийн дүрмийг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

2.1 Аймаг, сумдын ОНТХО-аар 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гүйцэтгэгчтэй байгуулсан барилгын ажлын гэрээнүүдэд Барилгын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Барилгын үйл ажиллагаанд оролцогчийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлыг даатгуулна. Даатгалыг захиалагч, гүйцэтгэгч урьдчилан тохиролцон барилгын ажил гүйцэтгэх гэрээнд тусгана” болон Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 2.4-т “Хөрөнгө оруулагч, захиалагч нь гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд Барилгын тухай хуулийн 8.2-т заасан даатгалтай холбоотой зохицуулалтыг тусгана” гэж заасан даатгалтай холбоотой шаардлагуудыг тусгаагүй байна.



2.2 ОНТХО-аар гүйцэтгэсэн зарим төсөл, арга хэмжээнүүдийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын явцад захиалагч, зохиогч, барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чанар, аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлт, ашиглалтад оруулсан баримт бичгүүд, аймгийн Төрийн архивд хадгалагдаагүй байна. Үүнд:

- Гурвантэс сумын залуучуудын хөгжлийн төвийн барилга барьж, ашиглалтад оруулах ажил - 3,959,796,639 төгрөг
- Цогтцэций сумын “Шинэ мянган айл” хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдын орон сууц барих ажил - 880,886,679 төгрөг,
- Хүрмэн сумын Эмийн сангийн барилгын засварын ажил - 80,126,723 төгрөг
- Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн амаржих газрын барилга засвар, тохижилтын ажил - 467,426,148 төгрөг
- Цэнгэлдэх хүрээлэнгийн хүндэтгэлийн индэр, үзэгчдийн суудал, тохижилт, ханын засварын ажил - 99,924,846 төгрөг,

2.3 Мөн Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа дуусгавар болсон дараа гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийсэн нь баримтаар нотлогдохгүй байна.

2.4 Иймд дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

3. Барилга байгууламжийн захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээг захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй байгуулаагүй байна.

3.1 Барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх, их засварын ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймаг, сумдын ЗДТГ-ууд дараах байгууллагуудтай гэрээ байгуулан санхүүжилт олгосон байна. Үүнд:

- Байгаль орчны газар - 45,187,869 төгрөг,
- Хүнс, хөдөө аж ахуйн газар - 18,020,916 төгрөг,
- Алтай-Өвөр сав газрын захиргаа - 3,333,000 төгрөг,
- Даланзадгад дулааны цахилгаан станц – 211,315,879 төгрөг,
- Даланзадгадын дулаан хангамжийн газар – 730,284,487 төгрөг,
- Их говийн инженерүүдийн холбоо – 391,500,000 төгрөг,
- Говийн алтан од ХХК – 1,262,700 төгрөг,

3.2 Гэвч эдгээр байгууллагууд нь захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад хамаарахгүй бөгөөд Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т “Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно”, Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 2.2-т “Захиалагчийн чиг үүргийг Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно”, 2.8-д “Захиалагч барилгын үе шатны ажилд хяналт тавихдаа техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна”, 2.9-д “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн захиалагч нь төрийн өмчит хуулийн этгээд болон зөвлөх үйлчилгээний эрх бүхий байгууллагыг сонгон ажиллуулж болно” гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.



3.3 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хууль, дүрмийн хүрээнд бүрэн хэрэгжээгүй, хяналтын тайлагнал хангалтгүй, техникийн баримт бичгийн бүрдүүлэлт дутуу, хөндлөнгийн хяналт, шинжилгээ хийгдээгүй, захиалагчийн зардлыг зориулалтын бусаар ашигласан зэрэг зөрчлүүдийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

БҮЛЭГ-2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗАХИАЛАГЧИЙН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн авто зам, замын байгууламжид захиалагч чиг үүргээ хэрэгжүүлсэн байна.

1.1 Авто замын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.1-т “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ” хэмээн заасан байна.

Хүснэгт-3. Аймаг, сумын ОНТХО-аар 2024 онд хийгдсэн авто зам, замын байгууламжийн ажил
/мянган төгрөг/

№	Сум нэрс	ОНТХО-аар хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний тоо	ОНТХО-аар хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төсөв	ОНТХО-аар хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 2024 онд санхүүжих дүн
1	Даланзадгад сум	1	730,000.0	730,000.0
2	Сэврэй сум	1	129,399.9	129,399.9
3	Ханбогд сум	4	20,618,933.5	20,618,933.5
Сумын нийт дүн		6	21,478,333.4	21,478,333.4
4	Аймаг	9	197,820,338.0	65,792,660.1
Нийт дүн		15	218,439,271.5	65,813,279.1

Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-н 2024 оны төсвийн тодотгол баталсан тогтоолууд

1.2 Дээрх авто зам, замын байгууламжийн ажлуудын захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээг дараах иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан байна. Үүнд:

- Даланзадгад сумын ЗДТГ нь Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар,
- Сэврэй сумын ЗДТГ нь ХЗТ Автозам ХХК, иргэн Ч.Дүүрэнбаатар,
- Ханбогд сумын ЗДТГ нь Гео зураглал ХХК, иргэн Г.Ариунцэцэг, Ч.Дүүрэнбаатар
- Аймгийн ЗДТГ-нь Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Гео зураглал ХХК, Аварга зам ХХК

1.3 Мөн аймгийн Засаг даргын 2024 оны 02 сарын 07-ны өдрийн А/142 дугаар захирамжаар “Манлай суманд төв суурин газрын тоосжилтыг бууруулах зорилгоор сумдын төвд хатуу хучилттай автозам, зогсоолыг барих” ажлыг Манлай сумын Засаг даргад эрх шилжүүлэн гүйцэтгүүлсэн байна.

1.4 Дээрх ажлыг Манлай сумын Засаг даргын 2024 оны 07 сарын 13-ны өдрийн А/123 дугаар захирамжаар “ЗГБ холдинг” ХХК-тай гэрээ байгуулан захиалагчийн хяналтын зардалд 19,750,524 төгрөг байхаар тусгасан байна. Тус ажилд хяналт тавьж ажиллахыг сумын ЗДТГ-н дарга, газрын даамалд үүрэг болгосны дагуу захиалагчийн хяналтыг гүйцэтгэсэн байна.



1.5 Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т *"Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно"*, Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 2.8-д *"Захиалагч Барилгын тухай хуулийн 37.1.4-т заасан барилгын үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна"* гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

1.6 Мөн Сэврэй сумын ЗДТГ, Ханбогд сумын ЗДТГ-тай авто зам, замын байгууламжийн ажлын захиалагчийн хяналтын гэрээ байгуулсан ХЗТ Автозам ХХК-ны тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, Ч.Дүүрэнбаатар нь захиалагчийн хяналт гүйцэтгэх эрх бүхий этгээд биш байна.

1.7 Энэ нь Авто замын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *"Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ"* гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

1.8 Цаашид дээрх алдаа, зөрчлүүдэд давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

2. Авто зам, замын байгууламжийн өндөр дүнтэй ажилд зөвлөх үйлчилгээ авсан байна.

2.1 Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журмын 2.1-т *"Зөвлөх нь замын барилгын ажлыг батлагдсан зураг, төсөв, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах, төслийн явцын тайлан мэдээ гаргах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ"* гэж заасан байдаг.

2.2 Тус журмын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газар нь "Аварга зам" ХХК-тай 2024 оны 07 сарын 1-нд ӨМАХААГ/20240101846 дугаартай 637,370,000 төгрөгийн *"Баяндалай – Ноён – Сэврэй – Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барих, 40 км авто замын ажлын техник, технологийн хяналт, зөвлөх үйлчилгээ"* үзүүлэх гэрээ байгуулсан байна.

2.3 Дээрх ажлуудад улсын комисс ажиллан Ноён – Сэврэй – Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барих, ПК174-ПК184 км-н ажлыг 2024-10-10 өдрийн У-2024/106, ПК184-ПК194км-н ажлыг 2024-10-10 өдрийн У-2024/105, ПК194-ПК209 км-н ажлыг 2024-11-25 өдрийн У-2024/144 улсын комиссын актаар хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

3. Авто зам, замын байгууламжид тавих захиалагчийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.1 Аймаг, Даланзадгад сумын ЗДТГ-тай гэрээ байгуулан авто зам, замын байгууламжийн захиалагчийн хяналтыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар гүйцэтгэсэн байна.



3.2 Тус орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудад захиалагчийн хяналт гүйцэтгэсэн инженерүүдийн ажлын тайлан хангалтгүй, үе шат бүрд хяналт хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй, гүйцэтгэгч компанийн гүйцэтгэлийг баталгаажуулсан тайлангаас өөр баримт байхгүй байна.

3.3 Иймд захиалагчийн хяналт гүйцэтгэх үеийн хяналтын тайланг сайжруулах, үе шат бүрийн хяналтыг гүйцэтгэсэн талаар дэлгэрэнгүй бичиж, тайлагнаж байх, алдаа, зөрчлүүдэд давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ-3 ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН БАЙНА.

1.1 Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 сарын 11-ны өдрийн 83 дугаар тушаалын хавсралтаар “Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрөл”, Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 2.7-д “Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу ашиглана” гэж заасан байдаг.

1.2 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 19/28 дугаар тогтоолоор баталсан ОНТХО-аас хэрэгжүүлсэн 174 төсөл, арга хэмжээнээс 113, сумдын ОНТХО-аас хэрэгжүүлсэн 361 төсөл, арга хэмжээнээс 111 барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, их засвар хийх, дулаан, цэвэр/бохир ус, цахилгаан хангамжийн шугам сүлжээ, авто зам, замын байгууламжийн ажлууд байна.

1.3 Дээр ажлуудад Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 2.7-д “Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу ашиглана” заасны дагуу захиалагчийн хяналтын зардлыг төсөвт өртөгт тусган баталсан байна.

1.4 Аймаг, сумдын ЗДТГ-аас Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Байгаль орчны газар, Алтай өвөр сав газрын захиргаа, Өмнөговь корпораци ОНӨААТҮГ, Хүнс хөдөө аж ахуйн газар, Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ, Даланзадгад дулааны цахилгаан станц ТӨХК болон бусад иргэн, аж ахуй нэгжт байгууллагуудтай захиалагчийн хяналтын гэрээ байгуулсан санхүүжилт олгосон байна.

Хүснэгт-4. Захиалагчийн хяналтын гэрээ байгуулан, санхүүжилт олгосон байдал.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт олгосон мөнгөн дүн /Мянган төгрөг/
1	Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ,	730,284.50
2	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	691,370.90
3	Өмнөговь корпораци ОНӨААТҮГ	572,264.60
4	Их говийн инженерийн холбоо	391,500.00
5	Их говийн инженерийн холбоо	391,500.00
6	Даланзадгад дулааны цахилгаан станц ТӨХК	151,909.80
7	Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК	48,000.00
9	Байгаль орчны газар	45,187.90
10	Хүнс хөдөө аж ахуйн газар	18,020.90
11	Алтай өвөр сав газрын захиргаа	3,333.00



12	Говийн алтан од	1,262.70
13	Ч.Мөнхжаргал	68,409.80
14	Л.Ганбаатар	43,532.60
15	Б.Ууганбат	33,260.00
16	Ч.Дүүрэнбаатар	30,266.50
17	Г.Ариунцэцэг	20,000.00
18	Л.Наранзул	20,000.00
19	Б.Мөнхзул	19,719.10
20	О.Отгонсүх	16,763.60
21	Ш.Эрдэнээ	13,420.90
22	Б.Нараншагай	4,532.30
Нийт дүн		3,314,539.1

Эх сурвалж: Аймаг, сумын ЗДТГ-н захиалагчийн хяналтын гэрээ, харилцах дансны хуулга

1.5 Аймаг, сумын ОНТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлыг төрийн байгууллагаас бусад иргэн, хуулийн этгээд гүйцэтгэж буй тохиолдолд тухайн зардлын зарцуулалтад хяналт тавих боломжгүй байна.

Хүснэгт-5. Захиалагчийн хяналтыг зардлыг зарцуулсан байдал.

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Зардлын зарцуулсан гүйлгээний утга	Зардлын мөнгөн дүн
1	Алтай өвөр сав газрын захиргаа	Дугуйны үнэ	1,320.0
		Засварын үйлчилгээний үнэ	773.0
		Албан томилолт	270.0
		Албан томилолт	270.0
		Шатахууны үнэ	700.0
2	Байгаль орчны газар	Албан томилолт	4,740.0
		Шатахууны үнэ	4,867.2
		Автомашин сэлбэг, засвар	12,549.0
		Тоног төхөөрөмж	10,230.0
		Гэрээт ажилтан цалин	2,560.0
3	Хүнс хөдөө аж ахуйн газар	Шатахууны үнэ	6,700.0
		Томилолт	3,500.0
		Автомашин сэлбэг, засвар	7,470.9
		Бичиг хэрэг	350.0
4	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	Гэрээт хяналт, сургалтын зардал	176,609.1
		Шатахуун	74,904.6
		Тоног төхөөрөмж, сэлбэг, засвар	90,109.7
		Шуудан, холбооны зардал	1,204.5
		Захиалагчийн хяналтын томилолт	44,236.1
		Гэрээт цалин	288,048.5
Нийт дүн			731,412.6

Эх сурвалж: Байгууллагуудын 2024 оны дансны хуулга

1.6 Аймаг, сумдын ЗДТГ-тай гэрээ байгуулсан Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Байгаль орчны газар, Алтай өвөр сав газрын захиргаа, Хүнс хөдөө аж ахуйн газруудын захиалагчийн хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг шалгаж үзэхэд Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь захиалагчийн



хяналтын зардлаас гэрээгээр үйлчлэгч 2, харуул 3 нийт 5 албан хаагчийг цалинжуулахад 288,048.5 мянган төгрөг зарцуулсан байна. Уг зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн.

1.7 Бусад байгууллагууд зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна. Цаашид Өмнөговь корпораци ОНӨААТҮГ захиалагчийн хяналтын зардлын санхүүжилтийг хүлээн авч, зарцуулах тусгай данс нээх шаардлагатай байна.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн хяналт хийсэн нь баримтаар нотлогдохгүй байна.
- Барилгын ажлын захиалагчийн дүрмийг мөрдөж ажиллах шаардлагатай байна.
- Барилга байгууламжийн захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээг захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй байгуулаагүй байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн авто зам, замын байгууламжид захиалагч чиг үүргээ хэрэгжүүлсэн байна.
- Авто зам, замын байгууламжийн өндөр дүнтэй ажилд зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байна.
- Захиалагчийн хяналтыг зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ӨМНӨГОВЬ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ

Батмөнхийн 2-218 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад хот, Өмнөговь аймаг, 46083
Утас: 99051416, 70531130
Цахим шуудан: umnugovi.hhog@gmail.com

2025.06.26 № 68
танай _____-ны № _____-т

Г ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН Г АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байдал, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитийн тайлан асуудлын бүртгэлд саналгүй.

ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ



Ч.ЭРДЭНЭДОРЖ

462593111



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

Нисэх 3-306 тоот, 6 дугаар баг, Даланзадгад сум,
Өмнөговь аймаг, 46082

Утас: (976) 70532917, 70532800

Цахим шуудан: umnugovi.ghbhbq@gmail.com

Цахим хуудас: www.omnogovi.gazar.gov.mn

2025.07.01 № 347
танай _____ -ны № _____ -т

┌ **ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН**
АУДИТЫН ГАЗАРТ └

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байдал, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, асуудлын бүртгэлд санал тайлбарыг хүргүүлж байна.

Хавсралт 2-хуудастай.

ДАРГА  П.ЗОЛЖАРГАЛ

4625030305
D:\2025 A5\A5.docx